

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНААС 2026 ОНД ЗАРЛАСАН ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ҮР ДҮН

Үндэсний геологийн албанаас Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд шинээр 1:25000-ны болон 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил гүйцэтгэх ҮГА/20260101009 дугаартай 6 багц, сэдэвчилсэн судалгааны ажил гүйцэтгэх ҮГА/20260101010 дугаартай 3 багц тендер шалгаруулалтыг 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зарлаж, 04 дугаар сарын 06-ны өдөр нээсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “холбогдох хууль” гэх) болон Захиалагчийн баталсан тендерийн баримт бичиг (цаашид “ТББ” гэх)-т заасны дагуу 2 тендер шалгаруулалтын нийт 9 багцад 10 ААН-ээс ирүүлсэн тендерийн баримт материалыг холбогдох хууль, журамд заасан ерөнхий шаардлага, шалгуурыг хангаж байгаа эсэхийг хянан үзээд дараах шийдвэрийг гаргасан. Үүнд:

I. 1:25000-НЫ БОЛОН 1:50000-НЫ МАСШТАБЫН ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮГА/20260101009 ДУГААРТАЙ 6 БАГЦ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ҮР ДҮН

Багц-1. Тэмээт уул-50 төсөл

Тендерийг нээхэд Тэмээт уул-50 төсөлд нэг ч оролцогч тендер ирүүлээгүй.

Шийдвэрлэсэн байдал:

Багц-1-д нэг ч оролцогч тендер ирүүлээгүй тул тендер шалгаруулалт амжилтгүй болсонд тооцож, хуулийн 24.5 дахь заалтыг үндэслэн дахин зарлахаар шийдвэрлэсэн.

Багц-2 буюу Хэцүү уул-50 төсөл

“Монголит” ХХК 2,283,763,276.00 төгрөгөөр, “Гео эрэл зураглал” ХХК 2,159,023,009.00 төгрөгөөр, “Эрдэст даян уул” ХХК 2,080,538,033.00 төгрөгөөр гүйцэтгэхээр үнийн санал ирүүлсэн.

Шийдвэрлэсэн байдал:

1. Эрдэст даян уул ХХК-ийн ирүүлсэн тендерийн материалыг хянан үзээд холбогдох хуулийн 15.6 дахь заалт, ТББ-ийн ТШЗ-ийн 19.1 дэх заалтыг хангаагүй тул тендерээс татгалзсан,
2. Монголит ХХК-ийн ирүүлсэн тендерийн материалыг хянан үзээд холбогдох хуулийн 27.5 дахь хэсэгт заасан эрэмбийн 2-т эрэмбэлэгдэж бага үнийн санал ирүүлээгүй тул тендерээс татгалзсан,
3. “Гео эрэл зураглал” ХХК-ийн ирүүлсэн тендерийн материалыг хянан үзээд харьцуулах үнэтэй хамгийн сайн тендерээр шалгарсан гэж шийдвэрлэн, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 28.1.1 дэх заалтад заасны дагуу гэрээ байгуулах мэдэгдэлийг хүргүүлсэн.

Багц-3 буюу Алтан ширээ уул-50 төсөл

Тендерийг нээхэд 1 оролцогч буюу “Соларфалкрам” ХХК болон “Гео эрин” ХХК-ийн түншлэл 2,834,827,554.59 төгрөгөөр гүйцэтгэх үнийн санал ирүүлсэн.

Шийдвэрлэсэн байдал:

“Соларфалкрам” ХХК болон “Гео эрин” ХХК-ийн түншлэлийн ирүүлсэн тендерийн материалыг хянан үзсэн үнэлгээний хорооны шийдвэрийн дагуу хамгийн сайн тендерээр шалгарсан гэж үзэн хуулийн 28.1.1 дэх заалтад заасны дагуу гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн.

Багц-4 буюу Төхөлийн элс-50 төсөл

Тендерийг нээхэд “Судалт мана” ХХК 4,214,091,189.00 төгрөгөөр, “Аполло майнинг” ХХК болон “Гео орон” ХХК-ийн түншлэл 4,196,099,943.00 төгрөгөөр үнийн санал ирүүлсэн.

Шийдвэрлэсэн байдал:

1. “Аполло майнинг” ХХК болон “Гео орон” ХХК-ийн түншлэлийн ирүүлсэн тендерийн материалыг хянан үзээд холбогдох хуулийн 7.1.10 дах заалт, ТББ-ийн ТШЗ-ийн 19.1 дэх заалтыг хангаагүй тул тендерээс татгалзсан,
2. “Судалт мана” ХХК-ийн ирүүлсэн тендерийн материалыг хянан үзсэн үнэлгээний хорооны шийдвэрийн дагуу хамгийн сайн тендерээр шалгарсан гэж үзэн хуулийн 28.1.1 дэх заалтад заасны дагуу гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн.

Багц-5 буюу Цахирын хяр-50 төсөл

Тендерийг нээхэд 1 оролцогч буюу “Монгол алт” ХК 3,228,437,838.00 төгрөгөөр үнийн санал ирүүлсэн.

Шийдвэрлэсэн байдал:

“Монгол алт” ХК-ийн ирүүлсэн тендерийн материалыг үзсэн үнэлгээний хорооны шийдвэрийн дагуу сайн тендер ирүүлсэн гэж үзэн хуулийн 28.1.1 дэх заалтад заасны дагуу гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн.

Багц-6 буюу Хархорин-25 төсөл

Тендерийг нээхэд 1 оролцогч буюу “Минторес” ХХК 5,451,765,220.00 төгрөгөөр гүйцэтгэх үнийн санал ирүүлсэн.

Шийдвэрлэсэн байдал:

“Минторес” ХК-ийн ирүүлсэн тендерийн материалыг хянан үзсэн үнэлгээний хорооны шийдвэрийн дагуу сайн тендер ирүүлсэн гэж үзэн хуулийн 28.1.1 дэх заалтад заасны дагуу гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн.

II. СЭДЭВЧИЛСЭН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮГА/20260101010 ДУГААРТАЙ 3 БАГЦ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ҮР ДҮН

Багц-1. Хөрсний геохими-эрдэслэг бүрлэдхүүн гео-орчны судалгаа төсөл

Тендерийг нээхэд 1 оролцогч буюу “БАСИС” ХХК болон “Судалт мана” ХХК-ийн түншлэл 4,744,582,161.00 төгрөгөөр гүйцэтгэх үнийн санал ирүүлсэн.

Шийдвэрлэсэн байдал:

“БАСИС” ХХК болон “Судалт мана” ХХК-ийн түншлэлийн ирүүлсэн тендерийн материалыг хянан үзсэн үнэлгээний хорооны шийдвэрийн дагуу сайн тендер ирүүлсэн гэж үзэн хуулийн 28.1.1 дэх заалтад заасны дагуу гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн.

Багц-2. Хойд нутгийн геологи, геохими төсөл

Тендерийг нээхэд 1 оролцогч буюу “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ 9,999,985,677.00 төгрөгөөр гүйцэтгэх үнийн санал ирүүлсэн.

Шийдвэрлэсэн байдал:

“Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ-ын ирүүлсэн тендерийн материалыг хянан үзсэн үнэлгээний хорооны шийдвэрийн дагуу сайн тендер ирүүлсэн гэж үзэн хуулийн 28.1.1 дэх заалтад заасны дагуу гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн.

Багц-3. Өмнөд нутгийн геологи, геохими төсөл

Тендерийг нээхэд 1 оролцогч буюу “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ 14,999,999,159.00 төгрөгөөр гүйцэтгэх үнийн санал ирүүлсэн.

Шийдвэрлэсэн байдал:

“Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ-ын ирүүлсэн тендерийн материалыг хянан үзсэн үнэлгээний хорооны шийдвэрийн дагуу сайн тендер ирүүлсэн гэж үзэн хуулийн 28.1.1 дэх заалтад заасны дагуу гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн.

**III. АМЖИЛТГҮЙ БОЛЖ ДАХИН ЗАРЛАСАН 1:50000-НЫ МАСШТАБЫН
ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖЛЫН ТЭМЭЭТ УУЛ-50
ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
УГА/20260101009/01 ДУГААРТАЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ҮР ДҮН**

Тэмээт уул-50 төсөл


Тендерийг нээхэд Мадерланд ХХК болон Мөнхийн вулкан ХХК-ийн түншлэл 2,671,380,858 төгрөг Белуха ХХК 2,566,253,140 төгрөгөөр гүйцэтгэхээр үнийн санал ирүүлсэн.

Шийдвэрлэсэн байдал:

1. “Мадерланд ХХК болон Мөнхийн вулкан ХХК-ийн түншлэлийн ирүүлсэн тендерийн материалыг хянан үзээд холбогдох хуулийн 15.6 дахь заалт, ТББ-ийн ТШЗ-ийн 19.1.1 дэх заалтыг буюу багийн бүрэлдэхүүний туршлага, ур чадварын шалгуурын доод үзүүлэлт хангаагүй, тул тендерээс татгалзаж шийдвэрлэсэн,
2. “Белуха” ХХК-ийн ирүүлсэн тендерийн материалыг хянан үзээд холбогдох хуулийн 15.6 дахь заалт, ТББ-ийн ТШЗ-ийн 19.1.1 дэх заалтыг буюу Багийн бүрэлдэхүүний туршлага, ур чадварын шалгуурын доод үзүүлэлт хангаагүй тул тендерээс татгалзаж шийдвэрлэсэн.
3. 2 оролцогчийн ирүүлсэн тендер ТББ-ийн ТШЗ-ийн 19.1.1 дэх заалтад тусгасан шаардлагыг хангаагүй тул тендерээс нэгэн зэрэг татгалзаж, тендер шалгаруулалт амжилтгүй болсон.

Мэдээлэл бэлтгэсэн:

УГА-ны мэргэжилтэн

 Х.Ганхуяг

2026.06.15